

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслийн хүчин чадал	4
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил	5
2.2. Физик газарзүйн нөхцөл	5
2.3. Агаарын чанар	7
2.4. Физик бохирдол	7
2.5. Хог хаягдал	8
2.6. Гадаргын ус	9
2.7. Хөрсөн бүрхэвч.....	10
2.8. Ургамлан нөмрөг	11
2.9. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	12
2.10. Нийгэм, эдийн засаг	14
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	17
3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл	17
3.2. Агаарт үзүүлэх нөлөөлөл	17
3.3. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл	17
3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл.....	18
3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	18
БҮЛЭГ-4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	20
4.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
4.6. Бомт-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	24
4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол	3
Хүснэгт 3. Агаарын чанарын хэмжилтийн дүн.....	7
Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн дуу шуугианы хэмжилт	8
Хүснэгт 4. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ	10
Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд	11
Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн	11
Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж	11
Хүснэгт 8. Хүн амын тоо /багаар/	15

Хүснэгт 9. Өрхийн тоо.....	15
Хүснэгт 10. Ерөнхий боловсролын сургуулийн тоо.....	15
Хүснэгт 11. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш	16
Хүснэгт 12. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо.....	16
Хүснэгт 13. Цэцэрлэгийн тоо.....	16
Хүснэгт 14. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо	16
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын нэгдсэн дүн	19
Хүснэгт 16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	20
Хүснэгт 17. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	21
Хүснэгт 18. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 20. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
Хүснэгт 21. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	24
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг /Google earth/.....	3
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал.....	4
Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг	5
Зураг 4. Монгол орны физик газарзүйн мужлал.....	6
Зураг 5. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг	6
Зураг 6. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал.....	7
Зураг 7. Хог хаягдлыг ангилан ялгах заавар	8
Зураг 8. Төслийн талбай орчмын усны сав газар	9
Зураг 9. Төсөл хэрэгжих талбай орчмын хөсрөн бүрхэвчийн хэв шинж	10
Зураг 10. Төсөл хэрэгжих талбайн ургамалжилтын зураг	12
Зураг 11. Талбайн гадаргын харагдах байдал	12
Зураг 12. Төслийн талбай орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутаг.....	13
Зураг 13. Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг ..	14
Зураг 14. Баянгол дүүргийн хүн амын насны бүтэц, 2024 оны байдлаар	15
Зураг 15. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс.....	17
Зураг 16. Мониторинг хийх, дээж авах цэгийн байршил.....	26

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Тунамал хийц” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ТЭЦ-4-ийн баруун хойно, “Эрчим Концерн” ХХК-ийн хажууд байрлаж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг
1	“Тунамал хийц” ХХК	5115523	9011084096	Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн байранд, Утас: 91993013

Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	106° 47' 35.27"	47° 53' 49.67"	14	106° 47' 46.94"	47° 53' 46.89"
2	106° 47' 36.07"	47° 53' 50.12"	15	106° 47' 46.92"	47° 53' 46.00"
3	106° 47' 37.48"	47° 53' 49.33"	16	106° 47' 44.46"	47° 53' 45.99"
4	106° 47' 39.15"	47° 53' 48.69"	17	106° 47' 44.27"	47° 53' 46.26"
5	106° 47' 40.23"	47° 53' 48.35"	18	106° 47' 43.05"	47° 53' 46.38"
6	106° 47' 41.85"	47° 53' 48.05"	19	106° 47' 43.01"	47° 53' 46.24"
7	106° 47' 43.23"	47° 53' 47.90"	20	106° 47' 42.01"	47° 53' 46.39"
8	106° 47' 43.98"	47° 53' 47.86"	21	106° 47' 42.05"	47° 53' 46.51"
9	106° 47' 44.09"	47° 53' 48.35"	22	106° 47' 41.87"	47° 53' 46.54"
10	106° 47' 43.39"	47° 53' 52.95"	23	106° 47' 40.33"	47° 53' 46.86"
11	106° 47' 43.76"	47° 53' 52.76"	24	106° 47' 38.82"	47° 53' 47.35"
12	106° 47' 44.41"	47° 53' 52.22"	25	106° 47' 37.90"	47° 53' 47.75"
13	106° 47' 44.90"	47° 53' 46.88"	26	106° 47' 36.44"	47° 53' 48.60"

Талбайн хэмжээ: 12360.0 м.кв

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг /Google earth/



1.2. Төслийн хүчин чадал

“Бетон зуурмагийн үйлдвэр” нь Барилга хот байгуулалтын яамны 2023 оны 08 сарын 15 ны өдөр гарсан МҮ 18-066/23 тоот Материалын үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, НМХГ-ын 02-04-190/209 тоот “Химийн бодисын агуулахын дүгнэлттэй, Монгол улсын хэмжээнд мөрдөх MNS 1185:98 стандартын дагуу M100-M450 маркийн бетоныг БНСУ-ын орчин үеийн дэвшилттэй техник тоног төхөөрөмжөөр тоноглогдсон компьютерийн удирдлагаар үйл ажиллагаагаа зохицуулдаг, цагт 120.0 м3 буюу өдөрт 1200.0 м3 бетон зуурмаг үйлдвэрлэх харьцангуй өндөр хүчин чадалтай бөгөөд хамтран ажиллаж буй 6-8 м3 багтаамжтай миксер автомашинаар тээвэрлэн 28-58 метрт хүрэх бетон шахагч автомашиныг /Солонгос/ ашиглан хөнгөн шуурхай бетон нийлүүлтийн үйлчилгээг үзүүлж байна. Бетон зуурмагийг үйлдвэрлэхэд ашиглагдах 1 нэр төрлийн химийн бодисыг ашиглах ба агуулахад нийт 1 ширхэг химийн бодис хадгалах юм. Бетон зуурмагийг үйлдвэрлэхэд ашиглах нэмэлт химийн бодисыг БНСУ-ын “Power Tech Co” ХХК-ын 20240226 тоот гэрээгээр импортлон оруулж ирэх бөгөөд шаардлагатай хэмжээ нь 178.2 тн/жил, нэг удаагийн таталтаар 19.8 тн-ийг авч агуулахад хадгалах юм.

Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал




БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил

“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт, 12360 м² талбайд байрлаж байна.

Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг




2.2. Физик газарзүйн нөхцөл


Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөссөн татам олон дэнж, Их Хэнтийн нурууны баруун өмнөд салбар уулс, түүний дэд мужийн ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Горхи, Тэрэлж, Богдхан, Сонгино Хайрхан Чингэлтэй, Баянзүрх зэрэг биеэ даасан өндөрлөг уулс, тэдгээрийн салбар уулсаар Туул голын 1250-1345 м үнэмлэхүй өндөр бүхий тэвш маягийн хөндийн 2.5-4.0 км хүртэл өргөссөн татам, дээрх уулсын энгэр, бэл, хормой, дэнжид тархан оршдог.

Төсөл хэрэгжиж буй талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид, Газарзүйн бүсчлэлээр ойт хээрийн бүсэд тус тус багтаж байна.

Зураг 4. Монгол орны физик газарзүйн мужлал



Зураг 5. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн зураг



2.3. АГААРЫН ЧАНАР

Агаарын чанарын хэмжилтийн дүн “Тунамал хийц” ХХК -ийн Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 -р хорооны нутагт хэрэгжиж буй “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн талбайн 1 цэгээс агаар дахь тоосжилт, агаарын чанарын индекс болон дуу чимээний түвшинг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 3. Агаарын чанарын хэмжилтийн дүн

№	Байршил	AQI	PM 2.5 (ug/m ³)	PM10 (ug/m ³)	НСНО (mg/m ³)	TVQC (mg/m ³)	Дуу чимээ (dB)	Байршил
1	1-р цэг 47°53'48.469" 106°47'37.640"	21	18.5	29.3	0.04	0.04	49.7	Үйлдвэрийн урд талбайд

Төслийн талбайд хийсэн хэмжилтийн дүнгээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17 -ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан Агаарын чанарын индексийн дүн, агаарын чанарын ангилалаар цэвэр, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд байна.

Төслийн талбайн орчимд хийж гүйцэтгэсэн тоосжилтын хэмжилт: Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад PM10 29.3 мкг/м³, PM2.5 18.5мг/м³ утгатай гарч байв. Агаарын чанарын стандарт MNS 4585:2025-д PM10-100 мкг/м³, PM2.5-37.5 мкг/м³ байна гэж заасан бөгөөд эдгээр утгаас бага гарч байв. Энэхүү утга нь тухайн үеийн нэг хэмжилтийн утга болно.

Зураг 6. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал



2.4. ФИЗИК БОХИРДОЛ

Шуугиан ба доргио нь хүрээлэн буй орчинд хэлбэлзэх долгион хэлбэрээр тархаж, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шуугиан ба доргионы тархалтын зүй тогтол нь ижил, байгаль орчин (хүн, амьтан, ургамал, хот, барилга байгууламж)-д үзүүлэх сөрөг нөлөө нь төстэй юм.

Механик системийн тодорхой давтамж бүхий хэлбэлзэх хөдөлгөөнийг доргио буюу чичиргээ гэж нэрлэдэг. Доргио нь газрын хөрс, шал, барилгын эд ангиудаар дамжин хүн, амьтан, ургамал, барилга байгууламж, хөшөө дурсгал зэрэгт нөлөөлөх бөгөөд ихэнх тохиолдолд шуугианы эх үүсвэр болдог.

Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн дуу шуугианы хэмжилт: Хээрийн судалгааны үеэр дуу шуугианы хамгийн их түвшин 49.7 дБ(А) байсан байна. Энэхүү дуу шуугианы хамгийн их утга нь 30 минутын /богино/ хугацаанд тасалдалтайгаар хэмжигдсэн.

Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн дуу шуугианы хэмжилт

№	Байршил	Дуу чимээ (dB)	Байршил
1	1-р цэг 47°53'48.469" 106°47'37.640"	49.7	Төслийн талбайд

2.5. Хог хаягдал

“Тунамал хийц” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн талбайд ил задгай овоорсон хур хог байхгүй байна.

Төслийн ажилчдын ахуйн хэрэглээнээс шил, лааз, хуванцар сав, гялгар уут, хоол, хүнсний хатуу хог хаягдал зэрэг үүснэ. Төсөл хэрэгжүүлэгч нь ахуйн гаралтай хог хаягдлыг “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан зайлуулж ажиллахыг зөвлөж байна.

Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс үүсэх энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалах зориулалтын хогийн сав байрлуулж тогтмол хугацаанд зайлуулах, мөн аюултай хог хаягдал үүссэн тохиолдолд /барилгын хог хаягдал/ тусгай зориулалтын сав, байранд түр хуримтлуулж “Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан ААН-тэй байгуулсан гэрээний дагуу зайлуулж байх зөвлөмжийг өгч байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагатай.

2) Дараах шаардлагыг хангасан хогийн савтай болох шаардлагатай. Үүнд :

- Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;
- Галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх;
- Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх

Ахуйн хатуу хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгах шаардлагатай.

Зураг 7. Хог хаягдлыг ангилан ялгах заавар




2.6. Гадаргын ус

Төслийн талбай ус зүйн сүлжээний хувьд Туул голын сав газарт багтана. Хот орчмын нутгийн геологийн тогтоц, чулуулгийн төрөл, тархалт, байршлын онцлогтой уялдан газар доорхи усны 4 уст бүрдэл, 4 уст давхарга, мөн олон жилийн цэвдэг болон шаварлаг хурдасны үеүд дээр байрласан өлгөмөл усны сул усжсан давхаргууд тархсан байна. Туул голын сав дахь газрын доорхи ус нь дөрөвдөгчийн сэвсгэр хурдас болох аллюви, деллювийн чулуулгаас зонхилон тогтсон элс, элсэнцэр хөрсөнд агуулагдах бөгөөд анхны уст давхрага 5 – 19 метр, хоёр дахь уст давхрага 35–120 метрийн гүнд оршино.

Бетон зуурмагийн үйлдвэрийн талбай нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 тоот тушаалаар баталсан Монгол орны 29 усны сав газраас Туул голын сав газарт хамаарагдаж байна.

Зураг 8. Төслийн талбай орчмын усны сав газар



Туул гол нь 6 дугаар эрэмбийн гол Хан Хэнтий нурууны Бага Хэнтий сарьдгийн өврийн салбар уулсаас эх авах Номин гол, Шороотын даваа (1918 м)-ны өвөр, Шар булгийн сарьдаг (2542 м)-ийн салбар уулсаас эх авах Шороотын давааны өврийн голын бэлчирээс Туул хэмээн нэрлэгдэнэ. Голын ус хурах талбай 48868.4 км², урт нь 871 км, хэвгий 0.0021. Голдирлын дундаж өндөр 1160 м, ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голын сүлжээний нягт бага 0.16 км/км², ус хураах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, ус хураах талбайн дундаж өргөн 56.1 км, сав газрын суналын зэрэг хамгийн их 16.5, ус хагалбарын шугамын тахиршлын зэрэг 2.6, хажуугийн хэрчигдэл бага 0.58, Хортор-Страхлерийн хуулиар голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.2, 3.05, 5.572 тус тус байна. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн сайр-горхи 1226, тэдгээрийн дундаж урт 2.3 км, ус хурах дундаж талбай 6.3 км², 2 дугаар эрэмбийн горхи 320, 3 дугаар эрэмбийн гол 64, 4 дүгээр эрэмбийн гол 14, 5 дугаар эрэмбийн гол 4 байна.

Хэнтий нурууны салбар уулсаас эх авах Галттай, Хийдийн гол, Хаг, Хонгор, Зүүн ба Баруун Баян, Заан, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол, горхи Туул голд цутгана.

2.7. ХӨРСӨН БҮРХЭВЧ


Хөрсөн бүрхэвч нь Төв Хэнтийн тойргийн баруун өмнөд хэсгийн уулын нугархаг хээрийн хар хүрэн хөрсний бүсэд хамрагдах ба уулсын орой, дээд хажуу налуугаар уулын сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрс, бэл хормойгоос дээшхи хажуу налууд уулын хар хүрэн хөрс зонхилон тархжээ. Ой бүхий хэсэгт хар шороон хөрс тархана. Уулын хөрс нь цулдмал чулуун дэвсгэр дээр, эллюви, эллюви-делювийн хурдас дээр тогддог учир чулуу ихтэй. Ялангуяа уулсын оройгоор эх чулуулаг шовойн ил гарсан байдаг. Хөрсний сэвсгэр хурдас харьцангуй нимгэн, чулуу ихтэй.

Төслийн талбай нь хар хүрэн хөрс тархсан бүсэд байрлаж байна. Судалгааны явцад 1 цэгт хөрсний дээж авч хөрсний агрохими болон хүнд металлын агууламжийг тодорхойлуулав. /2024 он/

Хүснэгт 4. Хөрсний хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Хар хүрэн хөрс	0.49	100.0
	Нийт	0.49	100.0

Зураг 9. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг



Нийт 2 цэгээс хөрсний дээж авч хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлт болон хөрсний эрүүл ахуй, хөрсний хүнд металлын бохирдлыг тодорхойлуулсан.

Хүснэгт 5. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ,d sm	Ялзмаг %	CaCO ₂ , %	NO ₃ , мг/ 100г	Солилцох суурь, мг- экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	0-20	8.27	0.092	0.23	1.98	0.0	0.39	22	8	4.0	13

Хөрсний лабораторийн шинжилгээний дүнгээр тус төслийн талбайн хөрс нь шавранцан механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж- ний дугаар	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ мм						
		1-0.25	0.25- 0.05	0.05- 0.01	0.01- 0.005	0.005- 0.001	<0.001	<0.01
1	0-20	34.4	36.0	9.0	4.6	6.5	9.5	20.6

Хүснэгт 7. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr /Хром/	Pb /Хар тугалга/	Cd /Кадми/	Zn /Цайр/	Cu /Зэс/	Ni /Никель/
1	0-20	54.6	33.4	0.0	31.9	10.7	8.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/							
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		150	100	3	300	150	150
Хортой агууламж /MNS 5850:2019/		400	500	10	600	400	1000
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1500	1200	20	1000	1500	1800

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/ атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад хөрсний дээжинд хар тугалга 33.4 мг/кг, цайр 31.9 мг/кг, зэс 10.7 мг/кг, хром 54.6 мг/кг, никель 8.5 мг/кг, кадми илрээгүй байна.


Шинжилгээний хариунаас харахад хөрсөн агуулагдаж буй хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

2.8. УРГАМЛАН НӨМРӨГ

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн мужийн Хэнтийн уулын тайгын тойрогт хамрагдана.

Бетон зуурмагийн үйлдвэр төслийн талбай нь ургамлан нөмрөгийн хувьд жижиг дэгнүүлт үетэн алаг өвст бүлгэмдэлд багтаж байгаа боловч үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөг устаж үгүй болсон, хөл газрын ургамал хашааны булангаар алаг цоог тархсан байдалтай байна.

Зураг 10. Төсөл хэрэгжих талбайн ургамалжилтын зураг




Зураг 11. Талбайн гадаргын харагдах байдал



2.9. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

Төсөл хэрэгжих газар нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй бөгөөд хамгийн ойр оршиж буй тусгай хамгаалалттай газар нутаг нь Богдхан уулын ДЦГ бөгөөд төслийн талбайгаас баруун урд зүгт 12.5 км зайтай оршиж байна.

Зураг 12. Төслийн талбай орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутаг



Богдхан уулын ДЦГ: 1294 онд гаргасан Монгол Их Юань улсын хууль цаазын 398 дугаар бүлэгт “Богд хан уул, Отгонтэнгэр, Хан Хэнтий, Алтайн нүсэр даваа” зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг дархан цаазтай болгож байжээ. XII-XIII зууны үед Ван хан Тоорил дархлан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн домог байдаг. 1778 онд Монголын сэхээтнүүдийн нэг сайд Юндэндоржийн санаачилгаар Богд хан уулыг дархан цаазтай болгож 1957, 1974 онуудад дахин бататган дархалж, 1995 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор дахин баталгаажуулсан байна.

2013 онд Байгаль орчин ногоон хөгжлийн яамны захиалгаар Богд хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа болон Монгол улсын их сургуулийн Археологийн тэнхим хамтарч Богдхан уулын “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг тэмдэгжүүлэх, хамгаалах, баримтжуулах” ажлыг хийсэн байна.

Богдхан уул нь том жижиг нийлсэн 44 амтай бөгөөд тус хайгуул судалгаагаар нийт 11 аманд түүх соёлын ямар нэгэн дурсгал байгааг олж тэмдэгжүүлэн баримтжуулсан байна. Хайгуул судалгаагаар Богдхан уулын дархан цаазат газрын Зүүн богины ам, Бумбатын ам, Төр хурахын ам, Сажин хурахын ам, Ширдэгтийн ам, Түргэний ам, Номт, Манзушир, Зүүн дэлгэрийн ам, Эх булаг, Өгөөмөрийн амуудад Дөрвөлжин булш 73, Хиригсүүр 77, дугуй чигжээст булш 39, цагирган булш 5, хүн чулуу 3, барилгын үлдэгдэл 1 нийт 197 түүхэн дурсгал бүртгэсэн байна. Тус түүхэн дурсгалууд нь хүрэл хүннү болон Монголын үе, Манжийн үе хамаарагдах дурсгалууд орно.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих талбай нь “Сонгинохайрхан уул” дүүргийн ОНТХГН-аас 4.7 км зайд оршиж байна.

Зураг 13. Төсөл хэрэгжих талбай орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг



2.10. Нийгэм, эдийн засаг

“Тунамал хийц” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлаж байна.

1965 онд Улаанбаатар хотын засаг захиргааны үндсэн нэгж болох Сүхбаатар, Октябрь, Найрамдал, Ажилчин гэсэн 4 районыг байгуулсан бөгөөд Баянгол дүүргийн үүсэл хөгжил нь Октябрын район нэртэйгээр эхэлсэн. Улмаар Монгол Улсад ардчилал, шинэчлэл өрнөсөн 1990 оны эхээр Улаанбаатар хотын дүүргүүдийн засаг, захиргааны байгууллагуудын ажлын ачааллыг жигдлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт төвлөрлийг сааруулах зорилгоор УИХ-ын 1992 оны наймдугаар сарын 18-ны өдрийн “Улаанбаатар хотын район, хороог татан буулгах, шинээр байгуулах тухай” 18 тоот тогтоол батлагдсанаар Октябрийн районыг хоёр хувааж Баянгол, Сонгинохайрхан дүүрэг болгон шинээр зохион байгуулсан юм.

Нийслэлийн Баянгол дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нэг бөгөөд 2949 га газар нутагтай, анхан шатны нэгж болох 34 хороотой. Зүүн талаараа Чингэлтэй, Сүхбаатар, урд хэсгээрээ Хан-Уул, баруун болон хойд талаараа Сонгинохайрхан дүүрэгтэй хиллэдэг, газар нутгийн хэмжээ бага ч хүн ам ихээр төвлөрсөн дүүрэг юм.

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Монгол Улсын эрчим хүчний хамгийн том үйлдвэр болох ДЦС-4” ТӨХК, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур болсон Монгол–Оросын хамтарсан ХНН “УБТЗ”, улсын чанартай томоохон эмнэлгүүд болох ЭХЭМҮТ, Улсын гуравдугаар төв эмнэлэг, ГССҮТ ЭХЭМҮТ байдгаас гадна МҮОНРТ, UBS зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагууд мөн МҮСТО, Төмөр замын дуу бүжгийн чуулга зэрэг урлаг соёлын томоохон байгууллагууд, Монголын хамгийн

эртний түүхэн дурсгалт газрын нэг болох Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд байрладаг юм.

Хүн ам, өрхийн мэдээлэл: Баянгол дүүрэг нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 71371 өрхийн 259411 хүн амтай бол 20-р хороо нь 1033 өрхийн 3464 хүн амтай байна. 2021 оноос 2024 онуудад 20-р хорооны хүн ам, өрхийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Хүн амын тоо /багаар/

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	1539252	1596335	1640781	1677872
Баянгол	236385	246886	252979	259411
20-р хороо	10609	4053	3670	3464

Зураг 14. Баянгол дүүргийн хүн амын насны бүтэц, 2024 оны байдлаар



Хүснэгт 9. Өрхийн тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	412527	431000	465059	475117
Баянгол	62784	65543	69519	71371
20-р хороо	3050	1136	1086	1033

Боловсрол, соёл шинжлэх ухаан: Баянгол дүүргийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар Ерөнхий боловсролын 55 сургуульд 2826 багш, 62764 өдрөөр суралцагч суралцаж байна. Дүүргийн хэмжээнд 81 цэцэрлэгт 17318 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Хүснэгт 10. Ерөнхий боловсролын сургуулийн тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	285	297	309	317

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Баянгол	49	51	52	55

Хүснэгт 11. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	15390	16040	16724	17158
Баянгол	2628	2712	2789	2826

Хүснэгт 12. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	340346	364793	381779	398437
Баянгол	56885	59213	61360	62764

Хүснэгт 13. Цэцэрлэгийн тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	677	639	649	655
Баянгол	101	86	79	81

Хүснэгт 14. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо

Засаг захиргааны нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	85119	127278	130092	125429
Баянгол	12588	18427	18519	17318

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл

“Тунамал хийц” ХХК-ийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн талбайн орчимд хийсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний судалгаагаар төслийн нөлөөллийг 2 бүсээр хуваан авч үзлээ. Үүнд :

- Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 100 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв

Зураг 15. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс



Төслийн шууд бус нөлөөллийн бүс болох 100 метр зайд барилга байгууламж өртөж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн эзэмшлийн талбайн ойр орчмын 100 м хүртлэх талбайд хяналт тавьж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэн ажиллах шаардлагатай.

3.2. АГААРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Тээврийн хэрэгслээс үүсэх тоосжилт, машин техникийн хөдөлгүүрээс гарах утаа

Энгийн хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалаагүйн улмаас салхинд хийсч орчныг бохирдуулах

Миксер угаах хэсгийн талбайгаас цагаан тоос босох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр шороон замаас тоос үүсэх

Бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарт нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэхээр байна.

3.3. ХӨРСӨНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид дараах нөлөөлөл үүснэ.

Төслийн үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламж, тээврийн хэрэгслийн зогсоолыг барих, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хог хаягдлыг хаях, ус зайлуулах суваг шуудуу татах, гэх мэт үйл ажиллагаанаас үүдэн хөрсөн бүрхэвч шууд ба шууд бус байдлаар элэгдэл эвдрэлд өртөж талхлагдана. Элэгдэл, эвдрэлд орж суларсан хөрс шорооноос агаарын бохирдол үүсэх бас нэгэн нөхцөл болно.

Төслийн үйл ажиллагаатай холбоотой хог хаягдал, шингэн түлшний шүүрэлт, асгаралт зэргээс үүдэн хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй. Хөрсийг бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тохиолдолд болзошгүй сөрөг нөлөөллийг бүрэн зогсоох боломжтой юм.

3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны зүгээс усан орчинд дараах нөлөөллийг үзүүлж болзошгүй.

Төсөл хэрэгжих явцад гүний худгаас ус авч ашиглах учир газрын доорх усны нөөцөд тодорхой хэмжээгээр шууд нөлөөлнө.

Төслийн талбай түүний орчим гол, горхи, булаг шанд, хаврын шар ус, хур борооны үерийн усаар тэжээгддэг хуурай сайр байхгүй учир гадаргын усны чанар болоод, нөөцөд төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөл үзүүлэхгүй.

Тээврийн хэрэгслээс дизель түлш алдагдах ослын үед нефть бүтээгдэхүүнийг үлэмж их алдвал хөрс, хэвгий газраар дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Тээврийн хэрэгсэл болон хүний хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтын нөлөөгөөр ургамлан нөмрөгт дам байдлаар сөрөг нөлөөлөл учруулна.

Нефтийн бүтээгдэхүүн алдагдсанаар газрын гадаргад он удаан жил хадгалагдаж задралынхаа явцаар ургамлын өсөх орчинг муутгана. Ингэснээр хөрсний ялзмагийн бодисын хэмжээг багасгаж, хар тугалгын хэмжээг нэмэгдүүлж, улмаар ургамлын өсөлт зогсон, хөрсний үржил шим бүрэн алдагдана.

Хөрсний үржил шим муудаж хог ургамал ихээр ургах

Барилгын материалыг газрын гадарга дээр ил удаан хугацаагаар хурааснаас хөрс дарагдаж ургамал ургах нөхцөлгүй болох

БҮЛЭГ-4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллах, байгалийн баялгийг зохистой ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах нь бидний зорилго юм.

“Тунамал хийц” ХХК нь Бетон зуурмагийн үйлдвэр төслийн хүрээнд 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт **6947.5** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

Энд тусгагдаагүй зардлууд нь үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ -тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын нэгдсэн дүн

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Нийт зардал (2025 он)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	2932.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Мян.төг	1012.5
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Мян.төг	1050.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян.төг	1700.0
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян.төг	253.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян.төг	-
	Дүн		6947.5

4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	АГААР ОРЧИН							
1	Ажилчдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуй	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Төслийн байршилд	мян.төг	2432.0		2025 онд	Агаарын тухай хууль, MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Орчны агаарын бохирдлыг бууруулах	Машин механизмын дутуу шаталт хөдөлгүүрийн үйл ажиллагаа бүрэн явагдаж байгаа зэрэгт хяналт тавьж оношилгоо засвар зэргийг байнга хийлгэх шаардлагатай	Ашиглаж буй техник хэрэгсэлд	мян.төг	500.0		2025 онд	
3		Ашиглаж буй шороон зам талбайд усалгаа хийх, замын тэмдэг, тэмдэглэгээ сайжруулах, хурдны хязгаарыг мөрдөн ажиллах	Төслийн байршилд болон ашиглаж буй зам талбайд	мян.төг	ҮА-ны зардалд		2025 онд	
ХӨРС, УРГАМЛАН НӨМРӨГ								
4	Хөрсний бохирдол	Хөрс бохирдсон тохиолдолд хөрсийг цэвэршүүлэн, шинж чанарыг сэргээх түргэн саармагжуулах материал нөөцлөх	ШТС -ын талбайд	мян.төг	ҮА-ны зардалд		Тогтмол	Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайдын 2003 оны 126/171 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт “Химийн бодисын хаягдлыг байгаль орчинд
5		Хөрсийг элэгдэл бохирдлоос хамгаалах, үүднээс орчны замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, засч сэлбэх	ШТС -ын талбайд	мян.төг	ҮА-ны зардалд		2025 онд	
6	Химийн бодисын уут савыг ил задгай хадгалснаар хүр	Химийн бодисын сав уутыг хадгалах түр цэгийг байгуулан хадгалах	Төслийн талбайд	мян.төг	Дотоод төлөвлөлтөөр		2025 онд	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	борооны усаар угаагдах, хөрсөнд нэвчилт өгөн орчныг хордуулах эрсдэлтэй							халгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах технологийн аргачилсан заавар”
УСАН ОРЧИН								
6	Усан орчны бохирдол	Барилга байгууламжийн гадна, дотор талыг тогтмол цэвэрлэж байх	ШТС -ын ашиглалтын үед	мян.төг	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол		Усны тухай хууль MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Нийт					2932.0			

4.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 17. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Төслийн талбайд тохижилтын дагуу мод бут тарьж хашаалах “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох	Талбайд мод тарих, Тарьсан мод бутны арчилгаа, тордолгоог хийх	0.1236 га-д Улиас, хайлаас тарих	ш	25ш Улиас мод	22.5	562.5	2025 онд
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох.	Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт санал болгосон газраас сонголт хийх		ш	20ш Улиас мод	22.5	450.0	2025 онд
Нийт							1012.5	

4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 18. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Болзошгүй осол, саатал, химийн бодис асгарах, техник технологийн дуу чимээ, галын гэнэтийн аюул үүсэх	Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар лабораторийн ажилчдад сургалт зохион байгуулах	Бүх ажилчдад	350.0	2025 онд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2		Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн олгож байх /витаминжуулсан ундаа, сүү/		Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
3	Гал унтраах багаж хэрэгсэл, галын аюулаас сэргийлэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Бүх ажилчдад	200.0	2025 онд	
4		Гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан батлах, гал унтраах хэрэгслийг бүрдлийг хангаж ажиллах	Төслийн хүрээнд	500.0	2025 онд	
5	Ажилчдын аюулгүй байдал	Ажилчдад ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, бүртгэл хөтлөх	ХАБЭА мэргэжилтэн хариуцан ажиллах		тогтмол	
Нийт зардал: 1050.0						

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлыг эх үүсвэрээс нь эхлэн ангилан ялгалт хийж, дахин ашиглахгүй хаягдлыг холбогдох байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах	Төслийн талбайд	75.0	75.0*12 сар=900.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус	Хог хаягдал түр хадгалах цэгийг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Төслийн талбайд	800.0	800.0	2025 онд	

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
бохирдож болзошгүй Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Төмрийн хаягдал гарсан тохиодолд ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн хүрээнд	Хэрэглээний хэмжээгээр	-		
	Сав баглаа боодол нь гэмтсэн тос, тослох материалын хаягдал гарсан тохиолдолд тусгай саванд цуглуулж тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Хэрэглээний хэмжээгээр		Сар бүр	
	Эзэмшил газрын гадна орчмын 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Төслийн хүрээнд	-	ҮАЗардалд тусгах	2025 оны 05 сараас	
Нийт				1700.0		

4.5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 20. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах	Улирал бүр	Дотоод төлөвлөлтөөр	Мэргэжлийн байгууллага, ХАБЭА мэргэжилтэн	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг бууруулах Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаварыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж авах
2	Гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх	2025 онд	--*--		
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулж, дүгнүүлэх	Тухайн оны 11 -р сарын 01 - нээс өмнө	--*--	Байгаль орчны мэргэжлийн байгууллага	
4	Шаардлагатай бичиг баримтын бүрдлийг бүрдүүлж ажиллах		--*--	2025 онд	
Нийт					

4.6. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 21. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	БОУАӨЯ	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг дүгнүүлэх	11 сарын 01-ний дотор	-	-

4.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайд	Агаар-1 47° 53'48.469" 106°47'37.640" Агаар-2 47° 53' 47.127" 106°47' 43.508"	Жилд 1 удаа	60.0 x 2 цэг = 120.0 /60.0 мян.төг – БОТЛаборатори/	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний ерөнхий, агрохимийн шинжилгээ	Хөрс элэгдэл орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Хөрс-1 47° 53' 48.060" 106°47' 43.260"	Жилд 1 удаа	27.0 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж - 27.0 төг,	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрс-1 47° 53' 48.060" 106°47' 43.260"	Жилд 1 удаа	30.0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 30.0 төг,	

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	Гэдэсний савханцар болон перпенгенсийн таньц, нянгаар бохирдох	Хөрс-1 47° 53' 48.060" 106°47' 43.260"	Жилд 1 удаа	30.0 /Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ 1 дээж 30.0 төг/	Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297:1991
Усан хангамж						
3.1	Гүний худгийн усанд шинжилгээ хийлгэх	Ундны усны эрүүл ахуйн үзүүлэлт	47° 53' 47.500" 106°47' 42.300"	Жилд 1 удаа	46.0	MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005
Нийт					253.0	

Зураг 16. Мониторинг хийх, дээж авах цэгийн байршил





Огноо/Date: 2025-07-31 16:23:40

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 32157510

Гүйлгээний дугаар /Poid: 1221472585

Системийн огноо/System Date: 2025-07-31 16:23:30

ДТ	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5011063836	ТУНАМАЛХИЙЦ	2,882,750.00 MNT	1.00
КТ	Банкны дугаар/Branch No МОFUMNUB	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN260090 000200555301	Нэр/Name	2,882,750.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ТУНАМАЛ ХИЙЦ ХХК 5115523 БО ХАМГА

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction informationЖурналын /Journal No: **20219710**Гүйлгээний дугаар /Poid: **1232283466**

Системийн огноо/System Date: 2025-08-11 14:30:07

ДТ	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount		Ханш/Rate
	5011063836	ТУНАМАЛХИЙЦ	591,000.00	MNT	
КТ	Банкны дугаар/Branch No MOFUMNUB	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН	591,000.00 MNT		1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN260090 000200555301	Нэр/Name			

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ТУНАМАЛ ХИЙЦ ХХК 5115523 БО ХАГ

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (мөнгө 2)

№ 0630430

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИНДЭРЛЭХ ИРНИЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

Энэ бүхий албан тушаалтны харьяалал байгууллага, ажла,
ир, ява, зүйл /.../ бн Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дм хэсэгт заасан.

агуулгын нэвсгэл О.ЗСОН нь

Холбоослогч (харьяалах улс, хуулийн этгэдийн ир, хүний өмөг, ир, регистрийсхортны дугаар, ажла, албан тушаал, хэрг)

болон нь /.../ хэргийн ир, ява, зүйл багтамтаар шалтан авч тогтоосондог,
Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дала хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна.

Ниймд холбоослогч /.../ хүн, хуулийн этгэдийн ир, ява, зүйл Зөрчилд Зөрчлийн тухай хуулийн
зүйлийн /.../ а заасны шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд
заасны үндсэндээ ШИНДЭРЛЭХ НЬ:

1. Холбоослогч /.../ хүн, хуулийн этгэдийн ир, ява, зүйл Зөрчилд Зөрчлийн тухай хуулийн
зүйлийн /.../ зүйл, хэрг, заалт а заасны дагуу /.../ шийтгэлийн төрөл, хэмжээ шийтгэл
оногдуулсугай.

2. Оногдуулах шийтгэлийн /.../ төгрөгний Төрийн сангийн /.../ тоот дансанд, холорол, нийлэн
төлбөрийн /.../ төгрөгний Төрийн сангийн /.../ тоот дансанд, зөрчил үйлдэх өлсөн мөнгөн өрлөгт
булсан төсөөг Төрийн сангийн /.../ тоот дансанд түр хугацааны хуудамд үүдэн авчлаас мөнгө 15 оногзийн
дотор бэлтгэр, бэлтгэр бусаар сайн дураар титж биелүүлэхийг заалсугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгэдийн /.../ зүйл амжиллага, ир, ява, зүйл
зүрчл-ыг /.../ хугацаагаар /.../ хугацаагаар, хүчгүй бэлтгэр /.../ ала бэлтгэр зүрчл /.../ ала хасах шийтгэл оногдуулсугай.

4. Төргүүлэн шийтгэлийн хэсэгтээ өлүүлэн /.../ үндсэндээ тогтоосон тул оногдуулах
төргүүлэн төргүүлэн шийтгэлийн /.../ хүнийг /.../ хугацааны дотор, /.../ хүнийг /.../ хугацааны дотор,
хүнийг /.../ хугацааны дотор хэсэгтээ сайн дураар биелүүлэхийг заалсугай.

5. Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 4.2 дугаар зүйл заасны дагуу хураан ажла.

А. Зөрчил үйлдэх өлсөн (ирийн, өрлөг), /.../ ала нь бэлтгэр доогуур зүрчл

Б. Зөрчил үйлдэх өлсөн (ирийн, өрлөг), /.../ ала нь бэлтгэр доогуур зүрчл

В. Зөрчил шалтан шийдвэрлэх ажлаагаар ая холбоослогчийн баримт болон /.../ зүйл, баримт бичиг

/.../ ала нь бэлтгэр доогуур зүрчл
/ир, зөрчл, тоо, хэмжээ, өлсөж тиймд-г Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон
ийн газрын тогтоолоор баталсан "Алмдээсний арга хэмжээ ажлаагаар холбоотой хураан авсан хөрийн, өрлөг, хд зүйл, хэргээс
холорол нийлэн титгүүл, үдсэн өрлөг бэлтгэр, үдсэн журм"-ын дагуу

шийдвэрлэхгүй.

6. Холбоослогч /.../ хүн, хуулийн этгэдийн ир, ява, зүйл Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 7.2
дугаар зүйлийн 3 дала хэсэгт зааснаар /.../ ир, ява, зүйл дотор /.../ үүргийн нийлэн биелүүлэхийг заалсугай.

7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгэдийн тогтоосон хугацаанд шийдвэрлэх биелүүлэхгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар
аалаа гүйцэтгүүлэн ир, ява, зүйл бүхий албан тушаалтан Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны харьяалал
шүүхэд хүсэт гаргана.

8. Шийдвэрлэх хэ хэмжээгээр Зөрчил шалтан шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомлол гаргах
эрхтэй боломж дарахгүй.

ШИЙДВЭР ГАРГАСАН

Энэ бүхий албан тушаалтан

ГАНЦШСАН

Холбоослогч



Дарга /.../

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction informationЖурналын /Journal No: **43244730**Гүйлгээний дугаар /Poid: **1147550916**Системийн огноо/System Date: **2025-05-23 17:25:52**

ДТ	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount		Ханш/Rate
	5011063836	ТУНАМАЛХИЙЦ	3,000,000.00	MNT	1.00
КТ	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name	3,000,000.00 MNT		1.00
	MOFUMNUB	ТӨРИЙН САН			
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name			
	MN390090 000200000906				

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ТУНАМАЛ ХИЙЦ ХХК 5115523 ТОРГУУЛ**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch: